



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СНАГ-2024/248/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Санхүү нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Улаанбаатар хот	Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Б.Лхагвацэнд Утас: 261885 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэгмиддорж Утас: 263533 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Интер Аудит ХХК Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхбаяр
	Утас: 99004839 Цахим хаяг: info@interaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН ТОГТВОРТОЙ  
АВТО ЗАМ, ТЭЭВЭР ТӨСЛИЙН  
ЗОХИЦУУЛАГЧ Х.БУЛГАА ТАНАА

2024.02.23 № 07/306

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төсөл хэрэгжүүлэгч нэгж нь төслийн зорилгын хүрээнд гудамж зам талбайг шинэчлэн сайжруулах зураг төсөл боловсруулах, ТЭЗҮ хийх, барилгын ажлыг гүйцэтгэх болон түүнд хяналт тавих зэрэг зөвлөх үйлчилгээнүүдийг хэрэгжүүлэхэд гадаад зээлийн эх үүсвэрээс 4,633,940.2 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан ба тээврийн ухаалаг систем болон зогсоолын системийн зураг төсөл боловсруулж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд БНСУ-ын Дэлхийн Банкны түншлэл Хүлээн авагчийн итгэлцлийн сангаас 257,141.8 мянган төгрөгийн шууд төлбөр хийгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Тайланд онд 5,045,000.0 мянган төгрөгийг улсын төсвийн гадаадын зээлийн эх үүсвэрээс, 500,000.0 мянган төгрөгийг буцалтгүй тусламжийн санхүүжилтээс олгохоор төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 5,300,131.6 мянган төгрөгийг зарцуулсан нь 95.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Сангийн сайдын 2021 оны 180 дугаар тушаалаар Төсөл хэрэгжүүлэх нэгжийн орон тоог 20 ажилтантай байхаар баталсан боловч гүйцэтгэлээр 16 ажилтантай байгаатай холбоотойгоор тайлант хугацаанд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга хэмжээ нь цаг хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

## Бусад асуудлын хэсэг

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Дэлхийн Банкаар хянуулан ТУХ-ын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлуулсан. Тайлант онд 1 зорилтын хүрээнд 23 худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу автомашин худалдан авах ажиллагаа хасагдаж, 1 худалдан авах ажиллагааны гэрээ байгуулагдсан боловч цуцлагдсан ба 87.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,665,583,519.21</b>	<b>2,242,500,692.53</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>2,665,583,519.21</b>	<b>2,240,378,025.17</b>
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>2,665,583,519.21</b>	<b>2,240,378,025.17</b>
31210	Төгрөг	7,836,425.12	2,240,378,025.17
31211	Төрийн сангийн харилцах	7,836,425.12	154,916,010.80
<b>31220</b>	<b>Гадаад валют</b>	<b>2,657,747,094.09</b>	<b>2,085,462,014.37</b>
31221	Төрийн сангийн харилцах	2,657,747,094.09	2,085,462,014.37
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		<b>873,250.23</b>
33402	Татвар, НДШ-ийн авлага	-	789,378.23
33510	Байгууллагаас авах авлага	-	83,872.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>150,766,040.81</b>	<b>201,923,490.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>150,766,040.81</b>	<b>201,923,490.00</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>150,766,040.81</b>	<b>190,402,942.05</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	108,389,262.79	224,511,672.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,118,612.13)	(89,690,057.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,339,000.00	65,156,545.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,843,609.85)	(9,575,219.33)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	<b>11,520,547.95</b>
39301	Программ хангамж	-	12,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(979,452.05)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН</b>	<b>2,816,349,560.02</b>	<b>2,443,174,765.40</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>101,365.68</b>	<b>101,365.68</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>101,365.68</b>	<b>101,365.68</b>
41361	Байгууллагад өгөх өглөг	38,571.42	38,571.42
41310	Ажилчдад өгөх өглөг	62,794.26	62,794.26
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,816,248,194.34</b>	<b>2,443,073,399.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,816,248,194.34</b>	<b>2,443,073,399.73</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,816,248,194.34</b>	<b>2,443,073,399.73</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-	2,816,248,194.34
51220	Тайлант үеийн үр дүн	2,816,248,194.34	(373,174,794.61)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,816,349,560.02</b>	<b>2,443,174,765.40</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН</b>	<b>3,121,050,000.00</b>	<b>4,891,081,978.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,121,050,000.00</b>	<b>4,891,081,978.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,121,050,000.00</b>	<b>4,891,081,978.40</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,121,050,000.00</b>	<b>4,891,081,978.40</b>
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	3,121,050,000.00	4,633,940,191.10
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>257,141,787.30</b>
122002	Хандив тусламж /гадаад/	-	257,141,787.30
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>572,872,830.63</b>	<b>5,248,100,947.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>572,872,830.63</b>	<b>5,248,100,947.73</b>
<b>210</b>	<b>Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>3,862,822,934.82</b>	<b>5,248,100,947.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>435,394,396.21</b>	<b>600,337,184.66</b>
210101	Цалингийн зардал	435,394,396.21	600,337,184.66
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>54,393,577.40</b>	<b>75,502,387.32</b>
210201	Эрүүл мэндийн даатгал	54,393,577.40	75,502,387.32
<b>2103</b>	<b>Байрны ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,720,800.00</b>	<b>94,442,236.18</b>
210304	Байрны түрээсийн зардал	46,720,800.00	94,442,236.18
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,003,556.32</b>	<b>28,691,194.16</b>
210401	Бичиг хэргийн зардал	9,569,156.32	13,486,213.80
210402	Тээвэр, шатахууны зардал	990,000.00	4,138,128.00
210403	Шуудан, холбооны зардал	444,000.00	7,815,543.27
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	-	3,251,309.09
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засвар зардал</b>	<b>35,742,842.62</b>	<b>12,332,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	35,742,842.62	8,260,000.00
210604	Урсгал засвар		4,072,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,700,178.82</b>	<b>4,351,512,938.78</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	5,700,178.82	4,351,512,938.78
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,962,221.98</b>	<b>85,282,506.63</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	14,962,221.98	85,282,506.63
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>2,548,177,169.37</b>	<b>(357,018,969.33)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>268,172,390.65</b>	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	268,172,390.65	-
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>16,155,825.28</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	16,155,825.28
<b>6</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>2,816,349,560.02</b>	<b>(373,174,794.61)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,121,050,000.00</b>	<b>4,633,940,191.10</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,121,050,000.00</b>	<b>4,633,940,191.10</b>
120	<b>Тусламжийн орлого</b>	<b>3,121,050,000.00</b>	4,633,940,191.10
122004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,121,050,000.00	4,633,940,191.10
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>723,421,081.38</b>	<b>5,042,989,859.86</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>723,421,081.38</b>	<b>5,042,989,859.86</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>723,421,081.38</b>	<b>5,042,989,859.86</b>
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>435,394,396.21</b>	<b>601,126,562.90</b>
210101	Үндсэн цалингийн зардал	435,394,396.21	601,126,562.90
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>54,394,577.40</b>	<b>75,502,387.32</b>
210201	Эрүүл мэндийн даатгал	54,393,577.40	75,502,387.32
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,720,800.00</b>	<b>94,442,236.18</b>
210304	Байрны түрээсийн	46,720,800.00	94,442,236.18
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,003,556.32</b>	<b>28,775,066.16</b>
210401	Бичиг хэргийн зардал	9,569,156.32	13,486,213.80
210402	Тээвэр, шатахуун	990,000.00	4,222,000.00
210403	Шуудан холбооны зардал	444,400.00	7,815,543.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,251,309.09
2106	<b>Эд хогшил урсгал засварын зардал</b>	<b>170,208,572.73</b>	<b>148,772,455.82</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	108,171,472.73	128,622,410.00
210602	Тавилга	57,339,000.00	7,817,545.82
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,698,100.00	8,260,000.00
210604	Урсгал засвар		4,072,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,700,178.72</b>	<b>4,094,371,151.48</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,700,178.72	4,094,371,151.48
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>2,397,628,918.62</b>	<b>(409,049,668.76)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>267,954,600.59</b>	<b>(16,155,825.28)</b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	267,954,600.59	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	267,954,600.59	-
25	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	-	<b>16,155,825.28</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	16,155,825.28
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>2,665,583,519.21</b>	<b>(425,205,494.04)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	2,665,583,519.21
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>2,665,583,519.21</b>	<b>2,240,378,025.17</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,816,248,194.34</b>	<b>2,816,248,194.34</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлэх үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(373,174,794.61)	(373,174,794.61)
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,443,073,399.73</b>	<b>2,443,073,399.73</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,545,000,000.00</b>	<b>5,300,131,647.16</b>	<b>244,868,352.84</b>	<b>95.6</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,545,000,000.00	5,300,131,647.16	244,868,352.84	95.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,545,000,000.00	5,300,131,647.16	244,868,352.84	95.6
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	687,009,808.00	601,126,562.90	85,883,245.10	87.5
210101	Үндсэн цалин	687,009,808.00	601,126,562.90	85,883,245.10	87.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,404,900.00	75,502,387.32	5,902,512.68	92.7
210201	Тэтгэврийн даатгал	81,404,900.00	75,502,387.32	5,902,512.68	92.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,483,200.00	94,442,236.18	15,040,963.82	86.3
210304	Байрны түрээс	109,483,200.00	94,442,236.18	15,040,963.82	86.3
2104	Хангамж, бараа материалын зардал	26,592,546.00	28,775,066.16	(2,182,520.16)	108.2
210401	Бичиг хэрэг	12,500,000.00	13,486,213.80	(986,213.80)	107.9
210402	Тээвэр, шатахуун	4,788,000.00	4,222,000.00	566,000.00	88.2
2104003	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,304,546.00	7,815,543.27	489,002.73	94.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйл	1,000,000.00	3,251,309.09	(2,251,309.09)	325.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,726,900.00	148,772,455.82	(62,045,555.82)	171.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	128,622,410.00	(98,622,410.00)	428.7
210602	Тавилга	43,726,900.00	7,817,545.82	35,909,354.18	17.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	13,000,000.00	8,260,000.00	4,740,000.00	63.5
210604	Урсгал зардал	-	4,072,500.00	(4,072,500.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,553,782,646.00	4,351,512,938.78	202,269,707.22	95.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,553,782,646.00	4,351,512,938.78	202,269,707.22	95.6
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,545,000,000.00</b>	<b>4,891,081,978.40</b>	<b>653,918,021.60</b>	<b>88.2</b>
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,045,000,000.00	4,633,940,191.10	411,059,808.90	91.9
350004	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	5,045,000,000.00	4,633,940,191.10	411,059,808.90	91.9

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

36	<b>Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих</b>	<b>500,000,000.00</b>	<b>257,141,787.30</b>	<b>242,858,212.70</b>	<b>51.4</b>
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	500,000,000.00	257,141,787.30	242,858,212.70	51.4
4	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,665,583,519.21		
5	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,240,378,025.17		
	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохируулгын зөрүү	-	(16,155,825.28)		
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>20</b>	<b>16</b>	<b>4</b>	
620001	Удирдах ажилтан	3	3	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	0	0	0	
620003	Үйлчлэх ажилтан	0	0	0	0.0
620004	Гэрээт ажилтан	17	13	4	0.0

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 271.8 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 271.8 сая төгрөгийн алдааг залруулав.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Дүн	Тоо
							Дүн	Тоо	Дүн	Тоо		
Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буруу бүртгэж тайлагнасан.	1	101.3			1	101.3	101.3	1				
Санхүүгийн тайлангийн өмнөх оны ашиг, алдагдлыг 101.3 мянган төгрөгөөр илүү толилуулж, 60.0 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээг орхигдуулсан. Мөн Дэлхийн Банкнаас шууд шилжүүлсэн худалдан авах ажиллагааны төлбөр болох 257,141.8 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тусгаж тайлагнасан байна.	3	257,303.2	1	60.0	2	257,243.2	257,303.2	3				
11 ажил гүйлгээний эдийн засгийн ангиллыг буруу толилуулсан байна.	11	7,605.7			11	7,605.7	7,605.7	11				
Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцоолж, толилуулсан байна.	1	6,791.0			1	6,791.0	6,791.0	1				
Дүн	16	271,801.2	1	60.0	15	271,742.2	271,801.2	16				

Аудитаар нийт 1.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ТХН нь 2 болон 4 дүгээр сард 2 ажилтны 1,235.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлж тайлагнасан, 10 дугаар сард 1 ажилтны цалинг 23.8 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	1	1,259.4	1	1,259.4									
Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй автомашиныг дахин үнэлгээ хийлгээгүй ашиглаж байна.	1						1						
Дүн	2	1,259.4	1	1,259.4			1						

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 50.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул 1 албан шаардлага хүргүүлж, 50.9 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй 3 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.	1		1			
Дүн	1		1			
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
Ажилчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй ба хөлсөөр ажиллах гэрээнд ажилчид ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтыг биеэр эдлээгүй тохиолдолд ээлжийн амралтын олговор олгохгүй гэсэн заалтыг үндэслэн ажилчдад ээлжийн амралтын цалин хөлс бодож олгоогүй байна.	1	50,984.0			1	50,984.0
Дүн	1	50,984.0			1	50,984.0
Нийт дүн	2	50,984.0	1		1	50,984.0